



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 19 өдөр

Дугаар 1/338

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

“Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 /а/, 29.1.6 /г/, 29.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит IV хуралдааны 01 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг борлуулах, баяр ёслол, нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулахад худалдаа, үйлчилгээ явуулахад ашиглагдах асар худалдан авахад шаардлагатай 8100000 /Найман сая нэг зуун мянган/ төгрөгийг Засаг даргын бусад зардлын жижиг худалдаа эрхлэгчдэд зориулсан стандартын худалдааны цэгүүдийг бий болгон ажлын байрыг нэмэгдүүлэх зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

2.Захирамжийн хэрэгжилтийг ханган, дээрх үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /н. Баяржаргал/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д. БАТЛУТ

D:(Zahiramj) A-4 doc

0200001576

Аймгийн Засаг даргын 2017 оны 6
дугаар сарын 19 өдрийн / дугаар
захирамжийн хавсралт / 38

**ӨРХИЙН ҮЙЛДВЭРЛЭГЧИД БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ БОРЛУУЛАХ
ЦЭГҮҮДИЙН ТОХИЖИЛТ ХИЙХ ТӨСӨВ**

Зорилго : Орон нутгийн өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг борлуулах, баяр ёслол, нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулахад худалдаа, үйлчилгээ явуулахад ашиглагдах асар худалдан авах

Д/д	Үйл ажиллагааны нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Асар 4x4 хэмжээтэй /цонхгүй/	3	ш	2,700,000	8,100,000
					8,100,000